## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

# Өмнөговь аймгийн Биеийн тамир,спортын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/019/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өмнөговь аймаг 2025 он | Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Ж.Болормаа<br>Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn<br>Аудитор: Э.Жаргал<br>Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 101

танай ______________-ны №______________ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ЭНХТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайланд тусгасан 37,020.0 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй, 97,418.8 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг баталгаажуулаагүй, 2,394.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг бөглөөгүй, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогоос эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,500.0 мянган төгрөг зарцуулсан, заалны үйл ажиллагааны орлогын тооцоо бодож санхүүгийн тайланд тусгаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгтэй нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

46250202 9

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,239,725.1 мянган төгрөгийн өртөг бүхий 400 метр тартан замыг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулж 112,311.4 мянган төгрөг, төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг 25 хувиар буюу 61,491.3 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэн 82.4 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **141,505,906.71** | **37,582,911.10** |
| **33** | **АВЛАГА** | 19,149,699.41 | 600,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,349,699.41 | 600,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 17,800,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 17,800,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 600,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 600,000.00 | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 600,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 121,756,207.30 | 36,982,911.10 |
| **351** | **Түүхий эд материал** | 98,676,733.70 | 5,172,112.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 98,300,328.70 | 5,001,000.00 |
| 35130 | Эм боох материал | 376,405.00 | 171,112.50 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,079,473.60 | 31,810,798.60 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,500,425.00 | 1,614,950.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,560,548.60 | 12,697,348.60 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 80,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 2,938,500.00 | 998,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 16,500,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,932,842,047.02** | **10,013,718,557.13** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 8,932,842,047.02 | 10,013,718,557.13 |
| **392** | **Биет хөрөнгө** | 7,813,530,037.03 | 8,897,487,327.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 17,377,527,208.85 | 17,826,527,208.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (10,534,541,988.01) | (10,952,493,109.42) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 254,400,000.00 | 254,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (31,172,916.85) | (73,464,583.57) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 677,002,143.82 | 660,625,154.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (249,369,358.16) | (355,697,871.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 472,577,336.90 | 537,498,896.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (200,542,389.52) | (235,628,327.00) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 42,650,000.00 | 1,282,375,174.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | (51,655,215.60) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,119,312,009.99 | 1,116,231,229.95 |
| 39301 | Програм хангамж | 16,998,900.00 | 16,998,900.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,861,690.01) | (6,942,470.05) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,106,174,800.00 | 1,106,174,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,074,347,953.73** | **10,051,301,468.23** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,349,699.41** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,349,699.41 | - |
| **413** | **Өглөг** | 1,349,699.41 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 1,349,699.41 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1,349,699.41 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,072,998,254.32** | **10,051,301,468.23** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,072,998,254.32 | 10,051,301,468.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,753,651,326.10 | 5,753,651,326.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 5,753,651,326.10 | 5,753,651,326.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,080,468,285.25 | 2,058,771,499.16 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,080,468,285.25 | 1,080,468,285.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 978,303,213.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,238,878,642.97 | 2,238,878,642.97 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,074,347,953.73** | **10,051,301,468.23** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,445,535,596.88** | **3,385,525,888.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,792,374,604.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,792,374,604.00 |
| 120009 | Бусад орлого | - | 9,430.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | | 1,775,865,174.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 16,500,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,445,535,596.88** | **1,593,151,284.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 689,158,800.00 | 779,851,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 689,158,800.00 | 779,851,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 414,003,396.88 | 461,944,684.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 377,995,708.00 | 424,328,604.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,780,000.00 | 12,431,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,227,688.88 | 25,184,280.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 342,373,400.00 | 351,355,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 342,373,400.00 | 351,355,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,789,546,275.12** | **2,405,097,199.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,789,546,275.12** | **2,405,097,199.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,506,064,742.79 | 1,979,083,150.05 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 431,431,680.46 | 622,046,028.51 |
| 210101 | Үндсэн цалин | 308,597,524.69 | 354,924,421.30 |
| 210102 | Нэмэгдэл | 44,186,968.17 | 139,038,250.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 54,572,033.09 | 35,602,000.00 |
| 210104 | Урамшуулал | 24,075,154.51 | 92,481,357.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,232,065.38 | 75,433,547.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,225,163.84 | 51,087,361.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,717,476.79 | 6,299,922.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,195,412.10 | 3,098,811.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,705.73 | 2,948,767.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,405,306.92 | 11,998,685.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,714,757.71 | 175,873,115.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,169,850.03 | 75,643,083.52 |
| 210302 | Түлш, халаалт | 60,523,576.68 | 69,644,593.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,021,331.00 | 30,585,438.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,098,201.00 | 116,766,446.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,013,200.00 | 1,519,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,500,000.00 | 2,394,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,533,001.00 | 1,501,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 599,600.00 | 510,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,487,000.00 | 7,292,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 9,965,400.00 | 103,549,046.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 43,150,250.00 | 75,708,460.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 3,695,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 43,150,250.00 | 72,013,460.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,177,000.00 | 1,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,177,000.00 | 1,370,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,333,130.00 | 25,298,953.84 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,022,000.00 | 19,609,300.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 407,250.00 | 440,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55,000.00 | 70,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 429,200.00 | 472,749.84 |
| 210807 | Газрын төлбөр | 4,419,680.00 | 4,706,904.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 825,927,658.24 | 886,586,598.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 357,532,380.00 | 191,083,409.39 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 468,395,278.24 | 695,503,189.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 283,481,532.33 | 426,014,049.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 118,277,462.00 | 194,770,772.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад тэтгэмж, дэмжлэг | - | 6,680,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 118,277,462.00 | 188,090,772.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 72,279,489.16 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,279,489.16 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 92,924,581.17 | 231,243,277.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 92,924,581.17 | 231,243,277.45 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(344,010,678.24)** | **980,428,688.50** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 2,125,474.59 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 2,125,474.59 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (2,125,474.59) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(344,010,678.24)** | **978,303,213.91** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,445,535,596.88** | **1,610,960,714.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **9,430.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 9,430.00 |
| 120009 | Бусад орлого | - | 9,430.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,445,535,596.88** | **1,610,951,284.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 689,158,800.00 | 779,851,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 689,158,800.00 | 779,851,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 414,003,396.88 | 479,744,684.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 377,995,708.00 | 424,328,604.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,780,000.00 | 12,431,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,227,688.88 | 42,984,280.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 342,373,400.00 | 351,355,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 342,373,400.00 | 351,355,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,445,535,596.88** | **1,608,320,714.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,445,535,596.88** | **1,608,320,714.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,162,054,064.55** | **1,182,306,664.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 431,431,680.46 | 622,046,028.51 |
| 210101 | Үндсэн цалин | 308,597,524.69 | 354,924,421.30 |
| 210102 | Нэмэгдэл | 44,186,968.17 | 139,038,250.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 54,572,033.09 | 35,602,000.00 |
| 210104 | Урамшуулал | 24,075,154.51 | 92,481,357.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,232,065.38 | 75,433,547.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,225,163.84 | 51,087,361.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,717,476.79 | 6,299,922.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,195,412.10 | 3,098,811.02 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 688,705.73 | 2,948,767.57 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,405,306.92 | 11,998,685.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,714,757.71 | 175,873,115.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 57,169,850.03 | 75,643,083.52 |
| 210302 | Түлш, халаалт | 60,523,576.68 | 69,644,593.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,021,331.00 | 30,585,438.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,132,601.00 | 11,806,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,013,000.00 | 1,125,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,500,000.00 | 2,394,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,533,001.00 | 1,501,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 599,600.00 | 510,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,487,000.00 | 6,275,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 177,500,450.00 | 74,658,460.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 43,643,300.00 | 2,645,000.00 |
| 210602 | Тавилга | 19,997,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 113,860,150.00 | 72,013,460.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,177,000.00 | 1,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,177,000.00 | 1,370,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,333,130.00 | 25,298,953.84 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,022,000.00 | 19,609,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 407,250.00 | 440,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 55,000.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | - | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 429,200.00 | 472,749.84 |
| 210807 | Газрын төлбөр | 4,419,680.00 | 4,706,904.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 357,532,380.00 | 195,820,359.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 357,532,380.00 | 195,820,359.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **283,481,532.33** | **426,014,049.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 118,277,462.00 | 194,770,772.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 6,680,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 118,277,462.00 | 188,090,772.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 72,279,489.16 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 72,279,489.16 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 92,924,581.17 | 231,243,277.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 92,924,581.17 | 231,243,277.45 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **2,640,000.00** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **2,640,000.00** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **2,640,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,640,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,640,000.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(2,640,000.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | (0.00) |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **5,753,651,326.10** | **2,238,878,642.97** | **1,080,468,285.25** | 9,072,998,254.32 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 978,303,213.91 | 978,303,213.91 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,753,651,326.10** | **2,238,878,642.97** | **2,058,771,499.16** | 10,051,301,468.23 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,131,206,600.00 | 917,101,720.87 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,131,206,600.00 | 914,461,720.87 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,121,779,800.00 | 906,509,920.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 575,271,200.00 | 492,093,616.07 |
| 210101 | Үндсэн цалин | 362,587,300.00 | 354,924,421.30 |
| 210102 | Нэмэгдэл | 128,976,600.00 | 84,430,494.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,610,300.00 | 35,602,000.00 |
| 210104 | Урамшуулал | 48,097,000.00 | 17,136,700.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 71,908,800.00 | 59,737,669.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,898,000.00 | 40,465,587.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,752,700.00 | 4,999,886.29 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,876,300.00 | 2,448,793.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,876,400.00 | 2,323,957.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,505,400.00 | 9,499,444.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 231,355,300.00 | 175,873,115.22 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 71,995,000.00 | 75,643,083.52 |
| 210302 | Түлш, халаалт | 118,387,500.00 | 69,644,593.70 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 40,972,800.00 | 30,585,438.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,158,600.00 | 8,306,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,177,200.00 | 1,125,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,452,500.00 | 2,394,450.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,506,800.00 | 1,501,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 588,600.00 | 510,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,433,500.00 | 2,775,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 125,689,800.00 | 74,658,460.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,689,800.00 | 2,645,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 120,000,000.00 | 72,013,460.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,452,500.00 | 1,370,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,452,500.00 | 1,370,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,045,200.00 | 7,498,953.84 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,452,500.00 | 1,809,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 833,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 441,400.00 | 440,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 83,900.00 | 70,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 34,300.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 490,500.00 | 472,749.84 |
| 210807 | Газрын төлбөр | 4,708,800.00 | 4,706,904.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 96,898,400.00 | 86,971,906.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 96,898,400.00 | 86,971,906.39 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,426,800.00 | 7,951,800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,426,800.00 | 7,951,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 6,680,000.00 | 6,680,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,746,800.00 | 1,271,800.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,640,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,640,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,640,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 1,131,206,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 779,851,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 779,851,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 351,355,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | 351,355,300.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **-** |

### 2.5.1 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **462,615,715.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **462,615,715.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 275,796,743.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 129,952,412.44 |
| 210102 | Нэмэгдэл | 54,607,755.44 |
| 210104 | Урамшуулал | 75,344,657.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,695,878.24 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,621,773.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,300,036.04 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 650,017.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 624,810.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,499,240.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,800,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 108,848,453.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,848,453.00 |

| | | |
|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 186,818,972.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 186,818,972.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 186,818,972.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 479,744,684.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 479,744,684.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 424,328,604.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,431,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 42,984,280.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,538,340.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 1,538,340.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Тайлант онд байгууллагын даргын А/112 тоот тушаалаар 103,549.0 мянган төгрөгийн бараа материал акталсан боловч худалдан зарцуулснаар тайлагнасан,
- Санхүү байдлын тайлангийн авлагын дүнг тодруулгын авлагын санхүүгийн үр дүнгийн тайлангийн тулган баталгаажуулахад 600,0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 2,640.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 5,006.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 110.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дүнг е-хуулганы дүнтэй тулган баталгаажуулахад 5,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа үйлчилгээний бусад зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,364.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал засварын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 288,863.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 1,131,206.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан

Аудитаар нийт 259,832.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 19,450.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 240,382.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогүй.

### 5.2 Албан шаардлага

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

*<u>Илрүүлэлт-1</u>:* Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс томилогдоогүй, санхүүгийн байдлын тайланд тусгасан 21,689,600.1 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-2</u>:* Тайлант хугацаанд 97,418.8 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх",13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-3</u>:* Тайлан тусгасан 37,020.0 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-4</u>:* Тайлант онд 103,549.0 мянган төгрөгийн бараа материал акталсан боловч өмч хамгаалах байнгын зөвлөл, устгалын ажлын хэсгийн тайлан байхгүй, бараа материалыг акталж устгасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна", 20.1.1-д"нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-5</u>:* Тайлант хугацаанд 2,394.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтад тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг бөглөж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-6</u>:* Тайлант хугацаанд заалны үйл ажиллагааны орлогын тооцоо бодоогүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх",14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д"бүх орлого" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэх

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт-1</u>:* Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогоос эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,500.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Холбогдох хууль, журамд нийцүүлэн үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулах журамтай болох. зөвлөмж хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-2</u>:* Тайлант хугацаанд бичиг хэргийн зардлаас 100.0 мянган төгрөгөөр цом,тууз худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх Зөвлөмж хүргүүлэх

*<u>Илрүүлэлт-3</u>:* Биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас 3,850.0 төгрөгийн контент хийлгэсэн байна.
Энэ нь УСНБББОУС-1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
*<u>Шийдвэрлэсэн нь :</u>* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах Зөвлөмж хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Тайлант онд байгууллагын даргын А/112 тоот тушаалаар 103,549.0 мянган төгрөгийн бараа материал акталсан болович худалдан зарцуулснаар тайлагнасан, | 1 | 103,549.0 | 1 | 103,549.0 | | | 1 | 103,549.0 | - | - | - | - |
| 2 | Санхүү байдлын тайлангийн авлагын дүнг тодруулгын авлагын санхүүгийн үр дүнгийн тайлангийн тулган баталгаажуулахад 600,0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, | 1 | 600.0 | 1 | 600.0 | | | 1 | 600.0 | | | | |
| 3 | Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 2,640.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, | 1 | 2,640.0 | 1 | 2,640.0 | | | 1 | 2,640.0 | | | | |
| 4 | Мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 5,006.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, | 1 | 5,006.5 | 1 | 5,006.5 | | | 1 | 5,006.5 | | | | |
| 5 | Мөнгөн гүйлгээний тайлангийн бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 110.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, | 1 | 110.0 | 1 | 110.0 | | | 1 | 110.0 | | | | |
| 6 | Нэмэлт санхүүжилтийн төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогын дүнг е-хуулганы дүнтэй тулган баталгаажуулахад 5,000.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, | 1 | 5,000.0 | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | | | |
| 7 | Мөнгөн гүйлгээний тайлангийн бараа үйлчилгээний бусад зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,364.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, | 1 | 1,364.5 | 1 | 1,364.5 | | | 1 | 1,364.5 | | | | |
| 8 | Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал засварын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг | 1 | 288,863.4 | 1 | 288,863.4 | | | 1 | 288,863.4 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зардалтай тулган баталгаажуулахад 288,863.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, | | | | | | | | | | | | |
| 9 | Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 1,131,206.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 1,131,206.6 | 1 | 1,131,206.6 | | | 1 | 1,131,206.6 | | | | |
| | Дүн | **9** | **1,538,340.0** | **9** | **1,538,340.0** | **-** | **-** | **9** | **1,538,340.0** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Тайлант хугацаанд заалны үйл ажиллагааны орлогын тооцоо бодоогүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| 2 | Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс томилогдоогүй, санхүүгийн байдлын тайланд тусгасан 21,689,600.1 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| 3 | Тайлант хугацаанд 97,418.9 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайлан гаргахдаа орлого, зарлагын баримт, шаардах хуудсыг байгууллагын дарга, нягтлан бодогч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй. | 1 | 97,418.9 | | | 1 | 97,418.9 | | | | | | |
| 4 | Тайлан тусгасан 37,020.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй байна | 1 | 37,020.1 | | | 1 | 37,020.1 | | | | | | |
| 5 | Тайлант онд 103,549.0 мянган төгрөгийн бараа материал акталсан боловч өмч хамгаалах байнгын зөвлөл, устгалын ажлын хэсгийн тайлан байхгүй, бараа материалыг акталж устгасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. | 1 | 103,549.0 | | | 1 | 103,549.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Тайлант хугацаанд 2,394.5 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтад тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг бөглөж, баталгаажуулаагүй байна. | 1 | 2,394.5 | | | 1 | 2,394.5 | | | | | | |
| 7 | Тайлант хугацаанд бичиг хэргийн зардлаас 100.0 мянган төгрөгөөр цом,тууз худалдан авсан байна | 1 | 100.0 | | | | | 1 | 100.0 | | | | |
| 8 | Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлогоос эрх бүхий байгууллагын шийдвэргүй 15,500.0 мянган төгрөг зарцуулсан | 1 | 15,500.0 | | | | | 1 | 15,500.0 | | | | |
| | **Дүн** | **8** | **255,982.4** | **-** | **-** | **6** | **240,382.4** | **2** | **15,600.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Биеийн тамир уралдаан тэмцээний зардлаас 3,850,000 төгрөгийн контент хийлгэсэн байна | 1 | 3,850.0 | - | - | - | - | 1 | 3,850.0 |
| | **Дүн** | **1** | **3,850.0** | - | - | - | - | **1** | **3,850.0** |